

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЯНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/150/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: Azzaya.Ts@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>НББББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>СӨБ</i>	<i>Сургуулийн өмнөх боловсрол</i>
<i>БСШУЯ</i>	<i>Боловсрол соёл шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Залруулсан алдаа	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав бөс, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БУЯНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Г.БАДАМХОРЛОО ТАНАА

2021.02.25 № 2/133
танай _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хүүхдийн сурч боловсрох орчин, эрүүл аюулгүй байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

021020632

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОРЛБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,379,606.0</u>	<u>30,383,373.0</u>
33	АВЛАГА	1,468,079.0	119,256.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	863,579.0	119,256.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	604,500.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	24,911,527.0	30,264,117.0
354	Хангамжийн материал	24,911,527.0	30,264,117.0
35420	Аж ахуйн материал	8,568,390.0	12,902,690.0
35440	Түлш, шатах тослох материал	235,000.0	500,100.0
35460	Хүнсний материал	11,872,260.0	12,625,450.0
35470	Бусад хангамжийн материал	4,235,877.0	4,235,877.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>672,060,326.7</u>	<u>660,278,387.0</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	672,060,326.7	660,278,387.0
392	Биет хөрөнгө	656,162,726.7	644,380,787.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	661,378,312.4	661,378,312.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,290,875.8)	(56,969,725.6)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,825,645.0	63,142,145.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,760,756.1)	(52,709,923.0)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,426,949.5	51,457,574.5
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,416,548.3)	(23,917,596.3)
39217	Ном	2,000,000.0	2,000,000.0
393	Биет бус хөрөнгө	15,897,600.0	15,897,600.0
39301	Програм хангамж	649,500.0	649,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(192,500.0)	(192,500.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,440,600.0	15,440,600.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>698,439,932.7</u>	<u>690,661,760.0</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,564,114.7</u>	<u>143,300.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,564,114.7	143,300.0
413	Өглөг	1,564,114.7	143,300.0

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	629,999.7	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	606,040.0	143,300.0
4136	Бусад өглөг	328,075.0	-
41361	Байгууллагад төлөх өглөг	328,075.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>696,875,818.0</u>	<u>690,518,460.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	696,875,818.0	690,518,460.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	623,175,477.0	623,175,477.0
512	Хуримтлагдсан үр дүн	(220,047,202.0)	(226,404,560.0)
51210	Өмнөх үеийн үр дүн	(204,986,838.1)	(220,047,202.0)
51220	Тайлант үеийн үр дүн	(15,060,363.9)	(6,357,358.0)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	293,747,543.0	293,747,543.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>698,439,932.7</u>	<u>690,661,760.0</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	297399336.5	319146825.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20925336.5	11979625.0
120	Нийтлэг татварын бус орлого	20925336.5	11979625.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20925336.5	11979625.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20925336.5	11979625.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276474000.0	307167200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259386500.0	293122600.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259386500.0	293122600.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	17087500.0	14044600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17087500.0	14044600.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	312459700.4	325504183.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312459700.4	325504183.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312452258.4	308839347.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181433605.0	218876802.1
210101	Үндсэн цалин	127959948.0	204642764.3
210102	Нэмэгдэл	38599431.0	13500537.8
210105	Гэрээт ажлын хөлс	863000.0	733500.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23282400.7	27120355.4
210201	Тэтгэврийн даатгал	16025056.5	18441841.7
210202	Тэтгэмжийн даатгал	1814336.1	2169628.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1451468.8	1735702.7
210204	Ажилгүйдлийн даатгал	362867.2	433925.7

210205	Эрүүл мэндийн даатгал	3628672.1	4339256.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17326158.0	13812000.0
210301	Гэрэл, цахилгаан	3395608.0	2235870.0
210302	Түлш, халаалт	13545550.0	11330000.0
210303	Цэвэр, бохир ус	385000.0	246130.0
2104	Хангамж, бараа материалын зардал	845380.0	3272025.0
210401	Бичиг хэрэг	144600.0	1655100.0
210402	Тээвэр, шатахуун	314780.0	406400.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	91500.0	100000.0
210404	Ном, хэвлэл	40000.0	67000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	254500.0	1043525.0
2105	Нормативт зардал	36796590.0	19595500.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	142000.0	765100.0
210502	Хоол, хүнс	36076830.0	17737000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	577760.0	1093400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1236600.0	0.0
210604	Урсгал засвар	1236600.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	121400.0	0.0
210702	Дотоод албан томилолт	121400.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	463200.0	312000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	463200.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50946924.8	25850664.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1704940.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2362350.0	721600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46879634.8	25129064.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7442.0	16664835.8
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7442.0	16664835.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7442.0	16664835.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-15060363.9	-6357358.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-15060363.9	-6357358.0

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	276474000.0	307167200.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276474000.0	307167200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	254386500.0	293122600.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	254386500.0	293122600.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22087500.0	14044600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22087500.0	14044600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	276474000.0	307167200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276474000.0	307167200.0

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	276466558.0	290502364.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180200085.0	218730463.5
210101	Үндсэн цалин	118484915.0	137648407.5
210102	Нэмэгдэл	36549440.0	65558656.1
210104	Урамшуулал	14273739.0	15523400.0
210105	Гэрээт ажлын хөлс	10891991.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24749500.0	26444270.7
210201	Тэтгэврийн даатгал	16829700.0	17747670.7
210202	Тэтгэмжийн даатгал	1980000.0	2174100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1583900.0	1739300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	395900.0	434800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3960000.0	4348400.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15848098.0	13935400.0
210301	Гэрэл, цахилгаан	3395608.0	2117500.0
210302	Түлш, халаалт	12067490.0	11417900.0
210303	Цэвэр, бохир ус	385000.0	400000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	768000.0	934200.0
210401	Бичиг хэрэг	144600.0	117200.0
210402	Тээвэр, шатахуун	274100.0	440300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	91500.0	96300.0
210404	Ном, хэвлэл	40000.0	67000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	217800.0	213400.0
2105	Нормативт зардал	42875335.0	26043630.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	142000.0	3169800.0
210502	Хоол, хүнс	42155185.0	20247530.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	578150.0	2626300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1236600.0	109200.0
210604	Урсгал засвар	1236600.0	109200.0
2107	Томилолт, зочны зардал	121400.0	0.0
210702	Дотоод албан томилолт	121400.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5263200.0	312000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5263200.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5404340.0	3993200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1762030.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3642310.0	3993200.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7442.0	16664835.8
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7442.0	16664835.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7442.0	16664835.8

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(220,047,202.0)	696,875,818.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(204,986,838.1)	711,936,181.9
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,060,363.9)	(15,060,363.9)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(220,047,202.0)	696,875,818.0
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(220,047,202.0)	696,875,818.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(220,047,202.0)	696,875,818.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,357,358.0)	(6,357,358.0)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,175,477.0	293,747,543.0	(226,404,560.0)	690,518,460.0

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	307167200.0	290502364.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307167200.0	290502364.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307167200.0	290502364.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225373700.0	218730463.5
210101	Үндсэн цалин	138489100.0	137648407.5
210102	Нэмэгдэл	71361200.0	65558656.1
210104	Урамшуулал	15523400.0	15523400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30425700.0	26444270.7
210201	Тэтгэврийн даатгал	21410600.0	17747670.7
210202	Тэтгэмжийн даатгал	2253700.0	2174100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1803000.0	1739300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	450700.0	434800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4507700.0	4348400.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13935400.0	13935400.0
210301	Гэрэл, цахилгаан	2117500.0	2117500.0
210302	Түлш, халаалт	11417900.0	11417900.0
210303	Цэвэр, бохир ус	400000.0	400000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	934200.0	934200.0
210401	Бичиг хэрэг	117200.0	117200.0
210402	Тээвэр, шатахуун	440300.0	440300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	96300.0	96300.0
210404	Ном, хэвлэл	67000.0	67000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	213400.0	213400.0

2105	Нормативт зардал	30300400.0	26043630.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3169800.0	3169800.0
210502	Хоол, хүнс	23004300.0	20247530.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4126300.0	2626300.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	109200.0	109200.0
210604	Урсгал засвар	109200.0	109200.0
2107	Томилолт, зочны зардал	121400.0	0.0
210702	Дотоод албан томилолт	121400.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343600.0	312000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143600.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5623600.0	3993200.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5623600.0	3993200.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	307167200.0	290502364.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	293122600.0	276457764.2
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293122600.0	276457764.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14044600.0	14044600.0
132001	Орон нутгийн төсвөөс	14044600.0	14044600.0

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадамхорлоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч үндсэн хөрөнгийн бүртгэл, хүнсний материалын зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багш бүр хичээлийн бэлтгэлийг чанартай ханган, багш, эцэг эхийн хамтын үйл ажиллагааг өргөжүүлж, хүүхдийн хөгжил төлөвшилд ахиц гаргаж ажиллана гэсэн зорилго дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны зорилго, төлөвлөлтийг хамтын оролцоотой тодорхойлох
- Эцэг эх, асран хамгаалагчтай хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлаар хамтран ажиллах гэрээ байгуулах
- Хамран сургах тойргийн хүүхдийн судалгаа гаргаж, цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх

- СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг хувилбарт сургалтад хамруулах, явуулын багшийг ажиллуулах
- “Авьяас”, “Номын гэгээ”, “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- “Чадварлаг багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж багш ажлын байрандаа хөгжих нөхцөл боломжоор хангаж, шат шатны сургалтад хамруулах
- Сургалтын гадна болон дотно орчны аюулгүй байдлыг хангаж учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 297399.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2974.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 317646.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3176.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7778.1 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	1468.0	119.2	-1348.8	-91.9%
Бараа материал	24911.5	30264.1	5352.5	21.5%
Үндсэн хөрөнгө	672060.3	660278.3	-11781.9	-1.8%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	698439.9	690661.7	-7778.1	1.1%
Богино хугацаат өр төлбөр	1564.1	143.3	-1420.8	-90.8%
Цэвэр хөрөнгө, өмч	696875.8	690518.4	-6357.3	-0.9%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	698439.9	690661.7	-7778.1	1.1%

Авлага дансны үлдэгдэл 119.2 мянган төгрөг болж 1348.8 мянган төгрөгөөр буурсан нь урд онд татварт ХХОАТ илүү шилжүүлж авлагаар бүртгэж тус онд 863.5 мянган төгрөгийг суутган тооцож, гэрэл цахилгааны авлага болох 604.5 мянган төгрөгийг мөн суутган тооцож, 2020 онд нэмж НДШ-ийн 119.2 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30264.1 мянган төгрөг болж 5352.5 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд аж ахуйн материалын эцсийн үлдэгдэл өмнөх оноос 4334.3 мянган төгрөгөөр өссөн, 719.1 кг махны нөөц бүрдүүлсэн зэргээс тус тус шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 672060.3 мянган төгрөг, оны эцэст 660278.3 мянган төгрөг болж 11781.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-аас ирсэн 10479.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, өөрийн хөрөнгөөр 2867.5 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж нийт 13389.6 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн байна.

Аймаг болон сумын ИТХ-ын шийдвэрээр акталж устгасан, шилжүүлсэн хөрөнгө байхгүй ба хөрөнгийн бууралт нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр оны эхэнд 1564.1 мянган төгрөг ба үүний 629.9 мянган төгрөг ажилчидтай холбогдсон өглөг, 606.0 мянган төгрөг хоолны өглөг, 328.0 мянган төгрөг нь байгууллагад төлөх өглөг байсныг барагдуулан ажиллаж оны эцэст 143.3 мянган төгрөгийн халаалт, шатахууны өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 690518 мянган төгрөг болж тайлант онд 6357.3 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 20247.4 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 20247.4 мянган төгрөгийн орлогоос 10445.7 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, 3042.9 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт тус тус буурч, 33736.1 мянган төгрөгөөр тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 11544.4 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 37443.1 мянган төгрөг буюу 20.4 хувиар, хангамж бараа материалын зардал 2426.6 мянган төгрөг буюу 387.0 хувиар, бусад урсгал шилжүүлэг 16657.3 мянган төгрөг буюу 2239.2 хувиар өссөн, нормативт зардал 17201.0 мянган төгрөг буюу 53.2 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 1236.6 мянган төгрөг буюу 100 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3514.1 мянган төгрөг буюу 9.7 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 310879,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 310879,7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газрын шийдвэрээр Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны төсвийг 310879.7 мянган төгрөгөөр баталсан ч дахин тодотгол хийж хоолны зардлаас 3712.5 мянган төгрөг дутуу санхүүжүүлж 307167.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 307167.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 14044.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 293122.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 14044.6 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 276457.7 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 290502.3 мянган төгрөгийг зарцуулж 16664.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290502.3 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 6643,3 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3981.5 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 2756.8 мянган төгрөгөөр, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлыг 1500.0 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 121.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 31.6 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1630.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 16664.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой хичээл практик, нормын хувцас зэрэг зардлуудын зарцуулах эрхийг нээж өгөөгүй мөн хүүхдийн хоолны гүйлгээ хийгдээгүй, багш нарт илүү цаг болон нэмэгдэл цалин хөлс олгоогүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал цалин, ндш, норм	6658.9
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хоолны зардал	2756.8
81831	Ээлжийн бүлэгт хамруулах, цалин ндш	5618.5
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах, хичээл үйлдвэрлэлийн зардал	1630.4
	ДҮН	16664.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 160 мэдээллээс хугацаандаа оруулсан 106 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу

сар бүрийн санхүүжилтийн орлогын 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Төвлөрүүлэх шилжүүлгээр гарсан зардлын 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 16312.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 644.9 мянган төгрөгийн бүртгэлийн алдааг аудитын явцад залруулж, 15667.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	15.6	4	15.6	0	0	100
Нийт дүн	4	15.6	4	15.6	0	0	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5553.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2825.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, ажилчдад олгосон махны үнийг суутган тооцоогүй 2728.0 мянган төгрөгийн төлбөр барагдуулах акт, 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар хөрөнгө орлогод аваагүй 2825.0 мянган төгрөгийн алдаа гарсныг залруулсан болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 2 алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх онц асуудал байхгүй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ҮНДСЭН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн бүртгэлд бараа материалын шинжтэй хүүхдийн углаа дэвсээ, хөнжлийг бүртгэж тайлагнасан байна.

Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам зөрчигдөх.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа бараа материалын шинжтэй углаа дэвсээ, хөнжил бусад бараа материалыг залруулж бүртгэл тайланд тусгах.

1.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2. БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРЦУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.

2.1. **Илрүүлэлт:** Хоол хүнсэнд хэрэглэх, мах ногоо зэргийг их хэмжээгээр нөөцөлсөн ба зарцуулахдаа эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг хэрэглээгүй байна.

Эрсдэл: Хүүхдийн хоолны чанар хүртээмж аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.22 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах, хэрэгцээнээс илүү хүнсний бүтээгдэхүүн нөөцлөхгүй байхад анхаарч ажиллах.

2.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр:	Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/150/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Буянт сумын Хүүхдийн цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн бүртгэлд бараа материалыг бүртгэсэн.	-	Зөвлөмж өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Г.Бадамхорлоо, Э.Чулуунцэцэг
2	Мах ногоо их хэмжээгээр нөөцөлсөн, зарлагдах аргыг буруу хэрэглэсэн,	-	Зөвлөмж өгөх		
3	Ажилчдад олгосон махны үнийг суутгал хийж аваагүй.	2728.0	Төлбөрийн акт		
4	Цэцэрлэгийн зөөлөн эдлэл орлого авч бүртгэж тайлагнаагүй.	2825.0	Залруулга		
ДҮН		5553.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 51/А 2170 425

Ховд

ХОА-2021/150/СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ховд аймгийн Буянт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар нэр бүхий 7 ажилчдад олгосон 341 кг махны тооцоо хийж 2728000 төгрөгийг суутгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн "6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "20.2.5.-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", "20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Дээр дурдсан 2728000 /хоёр сая долоон зуун хорин найман мянган/ төгрөгийг хавсралтад заасан багш ажилчдаар суутган Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2021 оны 4 дүгээр сарын 30-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадамхорлоо, нягтлан бодогч Э.Чулуунцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

ЦАЗЗАЯА

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545

021050023